



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 42 (179)

Монгол Улсын Хууль:

- *Конвенци болон хэлэлцээрүүдэд нэгдэн орох тухай*
Монгол Улсын Их Хурлын тогтоол:
- *Канад Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай*
Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:
- *Журал батлах тухай*
Монгол Улсын Засгийн газрын тогтоол:
- *Зөвлөл шинэчлэн байгуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арваннэгдүгээр сарын 14 №42 (179)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

454. Конвенцид нэгдэн орох тухай	(2000-11-2-ны хууль)	758
455. Хэлэлцээрт нэгдэн орох тухай	(2000-11-2-ны хууль)	758
456. Хэлэлцээрт нэгдэн орох тухай	(2000-11-2-ны хууль)	758
457. Хэлэлцээрт нэгдэн орох тухай	(2000-11-2-ны хууль)	758
458. Хэлэлцээрт нэгдэн орох тухай	(2000-11-2-ны хууль)	758

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

459. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 40	759
460. Канад Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай	Дугаар 41	759
461. Үнэт цаасны хорооны зарим гишүүдийг чөлөөлөх тухай	Дугаар 42	759
462. Үнэт цаасны хорооны зарим гишүүдийг томилох тухай	Дугаар 43	759

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

463. Журам батлах тухай	Дугаар 149	760
464. Будын Сумъяад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 150	764
465. Даржаагийн Чүлтэмд Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 151	764
466. Рүвжирийн Шагдарсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 152	764
467. Жанчивын Оюунгэрэлд Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 153	764
468. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 154	765

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

469. Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай	Дугаар 151	767
470. Зөвлөл шинэчлэн байгуулах тухай	Дугаар 152	767



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

Конвенцид нэгдэн орох тухай

1 дүгээр зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Нью-Йорк хотноо 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг

Конвенцид нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

Хэлэлцээрт нэгдэн орох тухай

1 дүгээр зүйл. 1989 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Мадрид хотноо гарын үсэг зурсан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрт зориулсан Протоколд нэгдэн

орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

Хэлэлцээрт нэгдэн орох тухай

1 дүгээр зүйл. 1968 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Локарно хотноо гарын үсэг зурсан Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай Локарногийн хэлэлцээрт нэгдэн

орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

Хэлэлцээрт нэгдэн орох тухай

1 дүгээр зүйл. 1957 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Ницц хотноо гарын үсэг зурсан Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох тухай Ниццийн

хэлэлцээрт нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

Хэлэлцээрт нэгдэн орох тухай

1 дүгээр зүйл. 1971 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Страсбург хотноо гарын үсэг зурсан Шинэ бүтээлийн олон улсын ангиллын тухай Страсбургийн

хэлэлцээрт нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ



— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг "1/Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга:

С.Чинзориг-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд," гэж өөрчлөн найруулсугай.

2.Тогтоолын 1 дэх хэсгийн 2 дахь заалтын

"-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга," гэснийг "Л.Энхтайван-Санхүү, эдийн засгийн дэд сайд,"; "-Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга," гэснийг "Ц.Мөнх-Оргил-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;" мөн хэсгийн 4 дэх заалтын "Д.Жанцан-Монголын ажил олгогч эздийн холбооны дэд ерөнхийлөгч;" гэснийг "Л.Нямсамбуу-Монголын ажил олгогч эздийн холбооны ерөнхийлөгч;" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Канад улсад элчин сайдын яам нээн ажиллуулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: Канад Улсын нийслэл Оттава хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар

тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Үнэт цаасны хорооны зарим гишүүдийг чөлөөлөх тухай

Үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Бямбажавын Гантөмөр, Догсомжавын Балдан-Очир нарыг Үнэт цаасны

хорооны гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2000 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Үнэт цаасны хорооны зарим гишүүдийг томилх тухай

Үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Баатарын Жүгдэр, Сандагдоржийн Жамъянсүрэн нарыг Үнэт цаасны хорооны

гишүүнээр тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2000 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Журам батлах тухай

1. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасныг үндэслэн "Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Уг зарлиг батлагдсантай холбогдуулан 1996 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 19 дүгээр

зарлигийг хүчингүйд тооцсугай.

3. Энэ зарлигийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигийн хавсралт

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ИРГЭДИЙГ ОРОЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хилийн тухай Монгол Улсын хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасны дагуу Монгол Улсын иргэн сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад оролцоно.

2. Аймаг, сумын Засаг дарга нь улсын хил хамгаалалтад сайн дурын үндсэн дээр оролцох иргэдийг ажил, үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн байрлалаар нь байнгын болон түр хугацаагаар улсын хил хамгаалалтад туслах хүч /цаашид "туслах хүчин" гэнэ/ болгон зохион байгуулж улсын хил хамгаалалтад оролцуулна.

3. Туслах хүчнийг хил орчмын аймаг, сум, багийн төв, хилийн боомт, хилийн сумангийн хэсэг, суурин газар, төмөр замын өртөө, зөрлөг болон шаардлагатай бусад газарт улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн аймгийн засаг даргын захирамжаар байгуулна.

4. Туслах хүчний зорилго нь улсын хил орчмын нутаг дэвсгэрт хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад хилчдэд туслахад оршино.

5. Улсын хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн улсын хил хамгаалалтад сайн дурын үндсэн дээр оролцох хүсэлтээ аймаг, сумынхаа Засаг даргад бичгээр гаргана. Уг хүсэлтийг өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх хил хамгаалах байгууллагын даргын саналыг үндэслэн тухайн аймаг, сумын Засаг даргын дэргэдэх хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлөөр хэлэлцэж Засаг даргын захирамжаар батална.

6. Улсын хил хамгаалалтад туслах

хүчний бүрэлдэхүүнд орсон иргэнийг туслах хүчний гишүүн гэнэ. Туслах хүчний гишүүн нь таних тэмдэг, үнэмлэхтэй байна. Тэдгээрийн загварыг хилийн цэргийг удирдах төрийн захиргааны байгууллага батална.

7. Туслах хүчний үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг удирдлага болгоно.

Хоёр. Туслах хүчний удирдлага

1.Туслах хүчнийг Монгол Улсын Хилийн тухай хуульд заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, түүний дэргэдэх орон тооны бус Зөвлөл, Улсын хил хамгаалах байгууллага тус тусын бүрэн эрхийн хүрээнд удирдлагаар хангана.

2. Хилийн аймаг, сумын Засаг даргын дэргэд Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл /цаашид энэ журамд "Зөвлөл" гэнэ/ ажиллана.

3.Хилийн аймаг, сумын Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн зорилт нь Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Засаг даргад туслах явдал мөн.

4. Аймгийн Зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга, орлогч дарга нь хилийн ангийн дарга, нарийн бичгийн дарга нь Засаг даргын тамгын газрын дарга байна. Аймгийн зөвлөлийн гишүүдэд аймгийн цагдаагийн хэлтэс /газар/, Тамгын газрын санхүүгийн болон нийгэм, эдийн засгийн асуудал хариуцсан нэгж, аймгийн тагнуулын алба,



цэрэг-иргэний хамгаалалтын штаб, холбооны газар, эрүүл мэндийн газар, мал эмнэлгийн алба, галын албаны дарга, хилийн сумдын засаг дарга нар байна. Аймгийн Засаг даргын захирамжаар бусад хүнийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж болно.

2. Аймаг, сумын засаг дарга нь шаардлагатай гэж үзвэл Аймаг, сумын зөвлөлийн нарийн бичгийн даргыг тамгын газрын бүтцэд багтаан орон тооны ажилтнаар томилж болно.

3. Сумын Зөвлөлийн дарга нь сумын Засаг дарга, орлогч дарга нь хилийн ангийн штабын ажилтан, нарийн бичгийн дарга нь сумын Засаг даргын тамгын газрын дарга байна. Сумын зөвлөлийн гишүүдэд сумын санхүүгийн тасгийн дарга, цагдаагийн байгууллага /тасаг, хэсэг/-ийн дарга, хэсгийн төлөөлөгч холбооны дарга, тагнуулын ажилтан, хүн эмнэлгийн эрхлэгч, мал эмнэлгийн байцаагч, багийн засаг дарга байна. Сумын Засаг даргын захирамжаар бусад хүнийг Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж болно.

4. Хилийн цагийн байдал, хил хамгаалалтын онцлогтой уялдуулан сумын Засаг даргын шийдвэрээр туслах хүчний багийн зөвлөлийг байгуулж болно. Багийн зөвлөлийн дарга нь багийн засаг дарга байх бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хилийн анги, салбарын удирдлагатай зөвшилцөн тогтооно.

Гурав. Туслах хүчний Зөвлөлийн үүрэг

1. Нутаг дэвсгэртээ байгаа улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн хил хамгаалалтад туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна.

2. Хилийн тухай хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хэрхэн сахин биелүүлж байгааг хянан шалгаж шаардлагатай арга хэмжээ авна.

3. Туслах хүчнийг улсын хил хамгаалалтад оролцуулах ажлыг улсын хил хамгаалах байгууллагатай хамтран зохион байгуулна.

4. Улсын хилийн болон хил орчмын дэглэм, боомтын журмыг сахиулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5. Улсын хил хамгаалалтад төсөвлөсөн нэмэгдэл зардлыг хилийн аймаг, сум, багийн

төсөвт тусгаж, зарцуулалтад нь хяналт тавина.

6. Улсын хилийн болон хил орчмын дэглэм, боомтын журам сахиулахтай холбогдсон асуудлаар саналаа зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

7. Хилийн бүс, зурваст ажил, үйлдвэрлэл эрхэлж байгаа туслах хүчний гишүүдийг оршин суугаа газраар нь хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулж удирдана.

8. Нутаг дэвсгэртээ байгаа хил хамгаалах байгууллагатай хамтран туслах хүчний гишүүдийн цугларалтыг жилд 2 удаа, нэгдсэн зөвлөлгөөнийг 1 удаа зохион явуулна.

9. Хил хамгаалах байгууллагаас хилийн цагийн байдлын тухай мэдээлэл авч, шаардлагатай гэж үзвэл орон нутгийн байгууллага, иргэд, хил орчмын оршин суугчдад мэдэгдэж, тэдний сонор сэрэмж, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

10. Улсын хил хамгаалалтад оролцох хүсэлт гаргасан иргэдийг хил хамгаалахад туслах хүчний бүрэлдэхүүнд оруулах эсэх асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

11. Хилийн цагийн байдал хүндэрсэн үед туслах хүчний гишүүдийг ажил, үйлдвэрлэлээс нь чөлөөлж, хил хамгаалалтад үүрэг гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулж удирдана.

12. Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг санаатай буюу давтан зөрчсөн Монгол Улсын иргэнийг хуулийн байгууллагад шилжүүлэх саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

13. Хил хамгаалах байгууллагатай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр хилийн бүс, зурваст айл өрхийг нутаглуулах арга хэмжээг зохион байгуулна.

14. Хил хамгаалалтад идэвх зүтгэлтэй ажилласан, хилийн болон хил орчмын дэглэм, боомтын журмын зөрчлийг удаа дараа илрүүлсэн туслах хүчний гишүүдийг өөрийн эрх мэдлийн хүрээнд шагнаж урамшуулах, дээд байгууллагын шагналд тодорхойлох, зөрчил гаргасан гишүүнийг туслах хүчний бүрэлдэхүүнээс хасах хүртэл арга хэмжээ авна.

15. Хилийн цагийн байдлын өөрчлөлттэй уялдсан нэмэгдэл чиг үүргийг гүйцэтгэж болно.

Дөрөв. Хил хамгаалах байгууллагын үүрэг

1. Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах энэхүү журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч туслах хүчний Зөвлөлүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллуулна.

2. Туслах хүчний Зөвлөлтэй хамтран гишүүдийн нэгдсэн цугларалт, зөвлөлгөөнийг зохион байгуулна.

3. Хилийн болон хил орчмын дэглэм, боомтын журам сахиулах ажиллагаанд гишүүдийг сургаж, дадлагажуулна.

4. Туслах хүчний гишүүдээс хил хамгаалалтад оролцох төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичгийг боловсруулахад туслана.

5. Туслах хүчний зөвлөл, гишүүдийг хилийн цагийн байдлын тухай мэдээллээр хангана.

6. Хил хамгаалалтад оролцох хүсэлт гаргасан иргэнийг судалж туслах хүчний бүрэлдэхүүнд оруулах, зөрчил гаргасан гишүүнийг туслах хүчний бүрэлдэхүүнээс хасах тухай саналаа Зөвлөлд оруулна.

7. Хил орчмын нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, иргэдэд улсын хил хамгаалалтын улс төр, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулж, хилийн тухай хууль тогтоомж, эрх зүйн актуудыг сурталчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

8. Хилийн бүс зурваст байнга байрлаж байгаа туслах хүчний гишүүдийг ердийн болон хүч нэмэгдүүлсэн хамгаалалт, хилийн эрлийн үед үүрэг гүйцэтгүүлэх хуваарь гаргаж, хилийн тодорхой хэсгийг хариуцуулан ажиллуулна.

9. Туслах хүчний гишүүдийн үүрэг гүйцэтгэж байгаа байдлыг шалгаж, урамшуулах, хариуцлага хүлээлгэх саналаа Зөвлөлд оруулж шийдвэрлүүлнэ.

Тав. Аймаг, сумын туслах хүчний Зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийн үүрэг, эрх

1. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хилийн аймаг, сумын Зөвлөлийн өдөр тутмын ажлыг хариуцан зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий төрийн захиргааны ажилтан мөн. Түүний үүрэг нь:

1.1. Туслах хүчний зөвлөлийн хурлыг

зохион байгуулж хурлаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангана.

1.2. Туслах хүчнийг улсын хил хамгаалалтад оролцуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг хил хамгаалах байгууллагатай хамтран боловсруулж зөвлөлийн даргад танилцуулна.

1.3. Туслах хүчний гишүүдийн байршил, хамгаалтад оролцуулах төлөвлөгөө, зураг, бүдүүвч хөтөлнө.

1.4. Хилийн зөрчилтэй холбоотой зохион байгуулалтын болон хилийн цагийн байдал хурцдахад туслах хүчний гишүүд, хил орчмын нутаг дэвсгэрийн иргэдийг хил хамгаалалтад оролцуулах арга хэмжээний төлөвлөгөө, зураг бүдүүвч боловсруулж, батлуулна.

1.5. Хилийн болон хил орчмын дэглэм, боомтын журам сахиулахад туслах хүчний гишүүд оролцсон ажлын дүн, илрүүлсэн зөрчлийн нэгдсэн бүртгэл судалгаа хөтөлж, тэдний ажлыг үнэлэн дүгнэж, гишүүдийн цугларалт, нэгдсэн зөвлөлгөөний үеэр мэдээлнэ.

1.6. Туслах хүчний гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл судалгаа хөтөлж, тэдний санал, гомдол, өргөдлийг хүлээн авч барагдуулан, салбар зөвлөлүүдийн ажлыг удирдаж, үүргээ гүйцэтгэж байгаа байдалд хяналт тавьж ажиллана.

1.7. Хил хамгаалалтад зориулсан зардлын зарцуулалтын тайланг нэгтгэн гаргана.

1.8. Хилийн цэрэгт алба хаах залуучуудыг судлах, шилж сонгох ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.9. Хилийн бүс зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин суугчдын бүртгэл судалгаа хөтөлж, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавина.

1.10. Шаардлагатай бусад судалгаа, бүртгэл хөтөлж Зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангана

2. Туслах хүчний гишүүний үүрэг нь:

2.1 Тогтоосон журмын дагуу хилийн манааны үүрэг гүйцэтгэнэ.

2.2 Өөрийн хяналт, ажиглалтаар илрүүлсэн хилийн зөрчлийн тухай хил хамгаалах байгууллагад цаг тухайд нь мэдэгдэнэ.

2.3 Улсын хилийн болон, хил орчмын дэглэм зөрчсөн, зөрчихийг завдсан этгээдүүдийг илрүүлэн саатуулна.

2.4 Хил орчмын нутаг дэвсгэрт байнга



болон түр оршин суух, ажил үйлдвэрлэл явуулахдаа улсын хил хамгаалалтад оролцоно.

2.5 Хилийн бүс, зурвас, боомтын журмын биелэлтэд хяналт тавина.

2.6 Цагийн байдлын дагуу шуурхай ажиллахад бэлэн байна.

2.7 Хил орчмын нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, ан агнуурын болон тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлнэ.

2.8 Мал бэлчээрээр хил давах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, харъяалах хил хамгаалах байгууллагадаа мэдэгдэнэ.

2.9 Улсын хил хамгаалалтад оролцож, үүрэг гүйцэтгэх үедээ таних тэмдгээ зүүж үнэмлэхээ биедээ авч явна.

2.10 Хил хамгаалалтын инженер техникийн байгууламжийг сэргээн засварлахад туслана.

2.11 Хилийн цагийн байдлын онцлогтой уялдсан бусад үүргийг биелүүлнэ.

2.12 Туслах хүчний гишүүн нь өөрөө хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил гаргахгүй байх үүрэгтэй.

3. Туслах хүчний гишүүний эрх нь:

3.1 Улсын хилийн бүс, зурваст зорчин явагчийн бичиг баримтыг шалгаж, зөрчил гаргагчдыг саатуулна.

3.2 Хилийн бүс зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчино.

3.3 Улсын хил хамгаалалтад идэвхтэй оролцсоны төлөө төрийн дээд шагнал, нутгийн захиргаа, цагдаа, хил хамгаалах байгууллагаас мөнгөн урамшуулал авна.

3.4 Хуулинд заасан хөнгөлөлт эдлэнэ.

3.5 Хил хамгаалалттай холбогдсон санал хүсэлтээ улсын хил хамгаалах байгууллага, туслах хүчний зөвлөлд тавина.

Зургаа. Туслах хүчний гишүүд үүргээ гүйцэтгэх эрх зүйн баталгаа

1. Улсын хил хамгаалалтад идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажилласан, онцгой гавъяа байгуулсан туслах хүчний гишүүнийг холбогдох журмын дагуу төрийн дээд одон медалиар шагнаж урамшуулна.

2. Улсын хил хамгаалах албан үүрэг

гүйцэтгэж яваад амь насаа алдсан туслах хүчний гишүүний гэр бүлд Хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1,2,7-д заасны дагуу нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгоно.

3. Хил хамгаалахад туслах хүчний гишүүнд хот хооронд онгоц, галт тэргээр зорчих тийгийг ээлж харгалзахгүй олгож, эмчилгээ хийлгэхээр сумаас аймагт, аймгаас Улаанбаатарт зорчих нэг талын зардлыг тухайн сумын төсөвт тусгасан хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардлаас олгоно.

4. Туслах хүчний гишүүн нь улсын хил хамгаалах албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн машин, мотоциклоо ашигласан бол зарцуулсан шатахууныг улсын хил хамгаалах байгууллагаас олгож, машин техникээ засварлахад мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

5. Хилийн дэглэмийн зөрчил, хил зөрчигчийг илрүүлэн саатуулсан, эд барааг хууль бусаар хил нэвтрүүлсэн, бэлтгэж завдаж байгаа тухай үнэтэй мэдээлэл өгсөн туслах хүчний гишүүнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13.14 дүгээр зүйлийн дагуу нутгийн захиргаа, хил хамгаалах, цагдаагийн байгууллага, сум, аймгийн Зөвлөлийн дарга урамшуулал олгож, Төрийн дээд ба Засгийн газрын шагналд тодорхойлно.

6. Туслах хүчний гишүүнийг үнэ төлбөргүй эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, урлагаар үйлчлэх тэдний хүссэн аль нэг тогтмол хэвлэлийг захиалж өгөх арга хэмжээг хил хамгаалах байгууллага зохион байгуулна.

7. Хил хамгаалахад туслах хүчний зөвлөлийн даргын шийдвэрээр улсын хил хамгаалах ажилд 5-аас доошгүй жил тасралтгүй идэвх зүтгэлтэй ажилласан туслах хүчний гишүүн 10 хүртэл хүнд хил хамгаалах байгууллагын ахлагчийн албан тушаалын 1-3 сарын цалинтай дүйцэх цалинг жилд нэг удаа олгоно.

8. Улсын хил хамгаалалтад биечлэн оролцоходоо зэвсэг, холбооны хэрэгсэл хүнс, тусгай зориулалтын хувцас /эсгий гутал, хөвөнтэй өмд, бээлий/-аар хил хамгаалах байгууллагаас хангагдана.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар
хот

**Будын Сумъяад Монгол Улсын
соёлын гавьяат зүтгэлтэн цол
хүртээх тухай**

Соёлын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж төрөөс соёлын талаар баримтлах бодлого, үзэл баримтлалыг боловсруулах, соёлын салбарын боловсон хүчин, материаллаг баазыг бэхжүүлэх, соёл, урлаг судлалыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Соёл урлагийн их сургуулийн соёл, урлаг

судлалын хүрээлэнгийн салбарын эрхлэгч Будын Сумъяад Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

**Даржаагийн Чүлтэмд Монгол
Улсын шинжлэх ухааны гавьяат
зүтгэлтэн цол хүртээх тухай**

Шинжлэх ухаан, боловсролын салбарт удаан жил үр бүтээлтэй ажиллаж цөмийн физикийн болон физикийн тулгуур, хавсарга судалгаануудыг амжилттай хийж, эрдэм шинжилгээний олон бүтээл туурвиж, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Дубна хот

дахь Цөмийн шинжилгээний нэгдсэн институтийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Даржаагийн Чүлтэмд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

**Рувжирийн Шагдарсүрэнд Монгол
Улсын хүний гавьяат эмч цол
хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж гэмтэл согогийн эмчлэгчид орчин үеийн шинэлэг аргуудыг нэвтрүүлэн, олон мянган хүнийг мэс заслын аргаар эмчлэн эрүүлжүүлэх, залуу эмч нарыг дадлагажуулан сургахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Гэмтэл согогийн клиникийн эмнэлгийн тасгийн эрхлэгч, зөвлөх эмч Рувжирийн Шагдарсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

**Жанчивын Оюунгэрэлд Монгол
Улсын худалдааны гавьяат
ажилтан цол хүртээх тухай**

Шатахуун хангамжийн байгууллагад мэргэжлийн өндөр үр чадвар гарган санаачилга, үр бүтээлтэй ажиллаж зах зээлийн эдийн засгийн шаардлагад нийцүүлэн шатахууны хангалт, үйлчилгээний оновчтой сүлжээг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, нефтийн бүтээгдэхүүнээр улс орны хэрэгцээг

хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж худалдаа, үйлдвэрлэлийн "Петровис" ХХК-ийн ерөнхий захирал Жанчивын Оюунгэрэлд Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар154

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, боловсрол, амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан соёл урлаг, банк, цагдаа, радио, шинжлэх ухаан, төр хүмүүсийг одон, медалиар шагнасугай. захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

- | | |
|----------------------------|--|
| 1. Шарав-Арилдын Базар | - Улсын төв номын сангийн хэлтсийн эрхлэгч |
| 2. Лувсангийн Балдан | - Хөгжим бүжгийн коллежийн хөгжмийн засварчин |
| 3. Балжиннямын Балдангомбо | - Хөдөө аж ахуйн их сургуулийн мал аж ахуйн механикуулалт, цахилгаанжуулалтын тэнхмийн эрхлэгч |
| 4. Батын Батчулуун | - Сонгодог урлагийн академик театрын гоцлол хөгжимчин |
| 5. Намсрайн Дамба | - Ховд аймгийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний "Ховд сафари" ХХК-ийн захирал |
| 6. Дуламын Жигмэдцэрэн | - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн жолооч |
| 7. Дамбилын Занданшарав | - Зах зээлийн сургалт зөвлөлөгөөний "Ундраа төв" ХХК-ийн захирал |
| 8. Жунайн Санжаажамц | - Улсын геодези, зураг зүйн газрын Тамгын хэлтсийн дарга |
| 9. Баянсангийн Үржинханд | - Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь "Спирт, бал бурам" ХК-ийн технологич |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | |
|---------------------------|--|
| 1. Далайханы Адасхан | - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын "Тулпар" ХК-ийн жолооч |
| 2. Дашдоржийн Алтанцэцэг | - Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Гадаад худалдааны арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга |
| 3. Нямын Амгаланбаатар | - Сэлэнгэ аймгийн Мандал сумын үйлдвэрлэл, худалдааны "Өгөөмөр Мандал" ХХК-ийн захирал |
| 4. Дагвын Бадарч | - Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг дарга |
| 5. Түвдийн Батбаяр | - Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн газрын дарга |
| 6. Дашзэвэгийн Батмөнх | - Улсын төв номын сангийн салбарын эрхлэгч |
| 7. Сангийн Баяраа | - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний "Шим" ХК-ийн ажилчин |
| 8. Халтарын Баярлхагва | - Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх нийгмийн даатгалын хэлтсийн дарга |
| 9. Содномдоржийн Бийлаа | - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч |
| 10. Сүхбаатарын Булган | - Худалдаа, хөгжлийн банкны нягтлан бодогч |
| 11. Сандагийн Бямбажаргал | - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч |
| 12. Цэрэнгийн Галсан | - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны "Улаанбаатар зочид буудал" ХК-ийн нярав |
| 13. Бадамын Гэрэл | - Нийслэлийн "АПУ" ХК-ийн мастер |
| 14. Даржаагийн Дарь | - Нийслэлийн "Хобби" дунд сургуулийн бага ангийн багш |
| 15. Нордогийн Дашнамжил | - Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын дэс түшмэл |
| 16. Лодойн Должин | - Дорнод аймгийн Хэрлэн сумын авто тээврийн "Дорнод-Гантулхүүр" ХХК-ийн ерөнхий захирал |
| 17. Милаевагийн Долгор | - Худалдаа, хөгжлийн банкны ерөнхий нярав |
| 18. Цэрэндашийн Доржпүрэв | - Булган аймгийн Гурван булаг сумын өндөр настан |

- | | |
|-------------------------------|--|
| 19. Баламын Доржхуяг | - Дорноговь аймгийн Мандах сумын Засаг даргын орлогч |
| 20. Ёндонгийн Дуламсүрэн | - Дархан-Уул аймгийн Дулааны цахилгаан станцын турбины машинч |
| 21. Аюурын Жамбалдорж | - Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн захирал |
| 22. Дашдаваагийн Жаргалсайхан | - Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн 9 дүгээр конторын дарга |
| 23. Дагвын Жүгдэрбарам | - Ховд аймгийн Засаг даргын орлогч |
| 24. Лхамсүрэнгийн Замбага | - Соёл, урлагийн их сургуулийн дуу хөгжмийн факультетийн декан |
| 25. Гандивын Индрээ | - Нийслэлийн 47 дугаар дунд сургуулийн дуу хөгжмийн багш |
| 26. Дугарын Магсаржав | - Хэнтий аймаг дахь зам засвар, арчлалтын "Харгуй" компанийн захирал |
| 27. Дашравдангийн Нарантуяа | - Нийслэлийн "АПУ" ХК-ийн ахлах мастер |
| 28. Сономдагвын Нарантуяа | - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Жон бэйс" ХХК-ийн захирал |
| 29. Даржаагийн Нямжав | - МАХН-ын Увс аймгийн хорооны дарга асан |
| 30. Дашдоржийн Оюун | - Үндэсний татварын ерөнхий газрын татварын улсын байцаагч |
| 31. Хаймчигийн Оюунчимэг | - Нийслэлийн Гэрлэх ёслолын ордны дарга |
| 32. Мятавын Равдандаш | - Монголын радиогийн Хэнтий аймаг дахь сурвалжлагч |
| 33. Лувсаншаравын Рэнцэндорж | - "Материалимпекс" ХК-ийн Архангай аймаг дахь салбарын дарга |
| 34. Дарамын Сандагсүрэн | - Нийслэлийн худалдаа, үйлдвэр, үйлчилгээний "Энигма" ХХК-ийн худалдааны менежер |
| 35. Загдын Санжлэрэнлэй | - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн жолооч |
| 36. Даржаагийн Совдоо | - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга |
| 37. Артхүүгийн Сосорбурам | - Завхан аймгийн Улиастай сумын "Завхан Баялаг" ХК-ийн цехийн мастер |
| 38. Надмидын Сэдхүү | - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын авто баазын жолооч |
| 39. Догсомын Тогооч | - Орхон аймгийн Баян-Өндөр сумын үйлдвэрлэл, үйлчилгээний "ВЭНС" ХХК-ийн дэд захирал |
| 40. Баянмөнхийн Тогтох | - Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь "Спирт, бал бурам" ХК-ийн ажилчин |
| 41. Самбуугийн Ухнаа | - Нийслэлийн "АПУ" ХК-ийн сантехникийн засварчин |
| 42. Нямаагийн Хажидсүрэн | - Нийслэлийн "Орхон" дээд сургуулийн захирал |
| 43. Эрдэнэзэгийн Цунцай | - Нийслэлийн "АПУ" ХК-ийн гагнуурчин |
| 44. Лувсангийн Цэнддорж | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Мөнхийн гал трейд" ХХК-ийн зөвлөх |
| 45. Батаагийн Цэрэннадмид | - Нийслэлийн "АПУ" ХК-ийн чанарын инженер |
| 46. Самбуугийн Цэрэндорж | - Соёл, урлагийн их сургуулийн урлаг судлалын салбарын эрхлэгч |
| 47. Шаравын Чунаг | - Шинжлэх ухааны академийн Тамгын газрын дарга |
| 48. Найдангийн Шагдарсүрэн | - Дархан-Уул аймаг дахь Дархан-Сэлэнгийн шугам сүлжээний газрын мотёрч |
| 49. Жамбалын Энэбиш | - Соёл, урлагийн их сургуулийн Соёл, урлаг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан |
| 50. Ойдовын Юра | - Монгол банкны ахлах хянан шалгагч |

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|------------------------|--|
| 1. Содномын Адъяасүрэн | - Нийслэлийн эрдэм шинжилгээ, жуулчлалын "Эр-Ши-Жу" ХХК-ийн жолооч |
| 2. Авъяагийн Баасанжав | - Орхон аймаг дахь Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн жолооч |
| 3. Нацагийн Бадамгарав | - Худалдаа, хөгжлийн банкны харьяа 804 дүгээр салбарын ахлах нярав |
| 4. Жамцын Галбадрах | - Хэнтий аймаг дахь зам засвар, арчлалтын "Харгуй" компанийн |



- | | |
|----------------------------|---|
| | автогрейдерчин |
| 5. Чулуунпүрэвийн Наранхүү | - Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь "Спирт, бал бурам" ХК-ийн ажилчин |
| 6. Жамцын Норолхоо | - Дархан-Уул аймаг дахь Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газрын мастер |
| 7. Дамдиндоржийн Ням-Осор | - Дархан-Уул аймгийн Дулааны цахилгаан станцын токарччин |
| 8. Яндагийн Очирпүрэв | - Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш |
| 9. Нацагийн Цэсээ | - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний "Шим" ХК-ийн чанар шалгагч |
| 10. Жамъянгийн Чулуунцэцэг | - Соёл, урлагийн их сургуулийн ардын хөгжмийн тэнхимийн ахлах багш |
| 11. Дамдинсүрэнгийн Энхээ | - Нийслэлийн 31 дүгээр дунд сургуулийн орос хэлний багш |
| 12. Дагмидын Янжмаа | - Худалдаа, хөгжлийн банкны тайлан бүртгэлийн газрын захирал бөгөөд ерөнхий нягтлан бодогч |

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

Даринжавын Сундуйсүрэн - Төрийн тусгай албан хаагчдын "Максим" эмнэлгийн нүдний их эмч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах албаны дарга Ц.Банзрагчид Байгаль орчны хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай"

Засгийн газрын 1996 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 273 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

Н.ЭНХБАЯР У.БАРСБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадын хөгжлийн албан ёсны тусламжийг үр дүнтэй ашиглах, нэгдсэн бодлогоор хангах ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий "Гадаадын зээл, тусламжийг зохицуулах Зөвлөл"-ийг шинэчлэн зохион байгуулсугай.

2. "Гадаадын зээл, тусламжийг зохицуулах

Зөвлөл"-ийн ажиллах журмыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зөвлөл байгуулах тухай" Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 102 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

Засгийн газрын 2000 оны 152 дугаар
тогтоолын хавсралт

“ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ”-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.“Гадаадын зээл, тусламжийг зохицуулах Зөвлөл” /цаашид “Зөвлөл” гэх/ нь гадаадын хандивлагч орнууд, олон улсын байгууллагуудаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар үзүүлж буй хөгжлийн албан ёсны тусламжийг үр дүнтэй ашиглах, гадаадын зээл, тусламжийн талаархи үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

2.Зөвлөлийг Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайд тэргүүлэх бөгөөд зөвлөлийн орлогч дарга нь Гадаад хэргийн дэд сайд байна.

3.Зөвлөлийн ажлын албаны үүргийг Санхүү, эдийн засгийн яам гүйцэтгэнэ.

4.Зөвлөлийн бүрэлдэхүүнд дэд сайд нар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга орно.

Хоёр.Зөвлөлийн эрх, үүрэг

5.Зөвлөл нь дор дурдсан эрхтэй байна:

а/Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаад, дотоод хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжигдэх төсөл, арга хэмжээний тухай болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлуудаар санал, дүгнэлт гаргаж тухайн асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;

б/үндэсний, бүсийн болон орон нутгийн хөгжилтэй холбогдсон эдийн засгийн гадаад харилцааны асуудлыг хэлэлцэх;

в/гадаадын зээл, тусламжтай холбогдсон асуудлаар хууль болон бусад шийдвэрийн тухай саналын төслийг авч хэлэлцэх;

г/гадаад орны Засгийн газар болон олон улсын байгууллагатай эдийн засаг, хөгжлийн талаар хамтран ажиллах зарчмын асуудлыг хэлэлцэх;

д/гадаадын зээл, тусламжийн хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилт, хүрсэн үр дүн зэрэг асуудлаар Засгийн газрын болон төрийн бус

байгууллагын тайлан, мэдээллийг сонсож, дүгнэлт гаргах.

Гурав.Зөвлөлийн үйл ажиллагаа

6.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байна. Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн даргын шийдвэрээр тухай бүр зарлан хуралдуулна. Зөвлөлийн даргын түр эзгүйд Зөвлөлийн орлогч дарга хурал зарлан хуралдуулж болно.

7.Зөвлөлийн хуралдаанд гишүүдээс гадна хэлэлцэж буй асуудал хариуцсан бусад албан тушаалтан оролцоно.

8.Зөвлөлийн гишүүд нь ажлын албаар дамжуулан хуралдаанд асуудал оруулах эрхтэй.

9.Хэлэлцэх асуудлын төслийг холбогдох мэдээллийн хамт зөвлөлийн ажлын алба гишүүдэд урьдчилан тараана.

10.Хэлэлцэж буй асуудлаар эцсийн шийдвэрийг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.

11.Зөвлөлийн шийдвэр нь зөвлөж, протоколын хэлбэртэй байна.

Дөрөв.Зөвлөлийн ажлын алба

12.Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Санхүү, эдийн засгийн яам зохицуулах бөгөөд Зөвлөлийн ажил хариуцсан нарийн бичгийн дарга нь Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын газрын дарга байна.

Тав.Бусад

13.Ажлын алба нь зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлтийн явцад хяналт тавина.

14.Зөвлөлийн үйл ажиллагаагай холбогдон гарах санхүүгийн зардлыг Санхүү, эдийн засгийн яамны жил бүрийн төсөвт тусгана.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргах.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрыг
Хэллэх хэсэгт хэллэв.

☎ 329487